

ТЕЛЕВИЗИЙН СЭТГҮҮЛЧДИЙН
ХЭЛ, ЯРИАНЫ ЗАРИМ АСУУДАЛ

Т.Өнөрсайхан*

* МУИС, Сэтгүүл зүйн тэнхимийн багш, магистр, докторант

Түлхүүр үг: телевиз, телевизийн хэл, үзэгч, сэтгүүлчийн боловсрол, хэл яриа

XXI зуунд мэдээлэл харилцаа улам бүр даяарчлагдаж, техник технологийн ололт, хөгжил дэвшил нь хүний амьдралын хэрэгцээнд хурдацтайгаар нэвтэрч байна. Үүний нэг бодит жишээ хүн төрөлхтний хөгжил түүхэнд оюун санааны маш том эргэлт авчирсан мэдээллийн хэрэгсэл бол телевиз юм. “Television” - алсыг харах гэсэн утгатай энэ үг манайд бүрэн утгаараа 1960-аад оны үед орж ирж, Монголд телевиз байгуулах тухай яригдаж эхэлсэн байдаг. Үүнийг дагаад сэтгүүл зүйн нэг төрөл болж телевизийн сэтгүүл зүй үүсэн бий болсон билээ. “Телевизийн сэтгүүл зүй гэдэг бол олон зүйл хэрэглүүрийн хамсал, олон мэргэжлийн хүч хөдөлмөрийн нэгдэл болж биеждэг нийлэг урлаг, мэдээллийн хэрэгсэл юм”¹ гэж сэтгүүл зүйн түүх судлаач, доктор, профессор Л.Норовсүрэн онцолсон байдаг. Нөгөө талаар телевизийн сэтгүүл зүй гэдэг бол техник дээр суурилсан уран бүтээл гэж хэлж болно. Уран бүтээлчдийн

бүтээгдэхүүн болох теле нийтлэл, нэвтрүүлгүүд нь уран бүтээл, техник үйл ажиллагааны тодорхой шаардлагыг хангах ёстой байдаг.

Өнөөдөр Монголд телевизийн салбар хөгжлийнхөө нэг үе шатанд явж, шинээр олон телевиз төрөн гарч байна. Нэг талаар телевизийн урлагт өрсөлдөөн бий болгож, үзэгчдийг сонголттой, мэдээллийг олон ургальч байдлаар хүргэх боломж олгож байгаа боловч нөгөөтэйгүүр сэтгүүлч, хөтлөгчдийн боловсрол, чадвар үзэгчдэд гологдож, чамлалттай байгаа нь ажиглагдаж байна.

Тооны хажуугаар чана-рыг мартаж болохгүй юм. “Тооноос чанарт шилжих, чанараас үр дүнд хүрэхийн төлөө манай хэвлэл мэдээллийн хэрэгслүүдэд цоо шинэ менежмент, шинэ сэтгэлгээ, идэвх санаачилга, бичлэгийн цоо шинэ арга барил шаардлагатай бөгөөд одоохондоо ийм хандлага ихэнх сонин, хэвлэл, радио телевизэд ажиглагдахгүй байна” гэж сэтгүүл зүй судлаач, доктор, профессор М.Зулькафиль тэмдэглэсэн байдаг². Үнэхээр ч Монголын телевизүүдийн эфирийн соёлын хэм хэмжээ доогуур түвшинд байгааг хүлээн зөвшөөрөх цаг болсон

юм. Теле нэвтрүүлгийн агуулга, ур чадвар, ялангуяа сурвалжлагч, нэвтрүүлэгч, хөтлөгчдийн харилцааны соёл, төрөлх хэлний мэдлэг өнөөгийн шаардлагад хүрэхгүй байна.

Хэл шинжлэлийн эрдэмтэд сонин, телевизийн хэл асар их доройтож, монгол хэлийг мөхөх аюул руу хөтөлж байгаад сэтгэл зовнин, хэлний засаглал тогтоох тухай идэвхтэй ярьж хөөцөлдөж эхэлжээ. Үүний үрээр ч төр засаг анхааралдаа авч Монгол Улсын

Ерөнхийлөгчийн ивээл дор даяаршлын үеийн хэлний бодлого, түүнд хэвлэл мэдээллийн хэрэгслийн гүйцэтгэх үүргийн талаар эрдэм шинжилгээний бага хурал хүртэл зохион байгуулж, санал зөвлөмж гаргасан билээ. "Олон нийтийн дунд ч сонин

хэвлэл, телевизийн хэл ядуурч байгааг шүүмжлэн хэлэлцэх нь олширсон. Телевизийн соён гэгээрүүлэх үүрэг дэлгэцийн соёлыг сахиж, төрөлх хэлээрээ зөв сайхан ярихаас эхлэх ёстой гэж захын үзэгч шаардаж байна"³. Телевизийн хэл найруулга, телевизээр хэлсэн үг яриа үзэгчдийн дунд шууд тусгал болон бууж байгаа нь нууц биш юм.

Хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтнууд оюунлаг, эрдэмлэг, гэгээлэг нийтлэл, нэвтрүүлэг монгол утга зохиолын хэлний хэм хэмжээнд нийцүүлэн учир шалтгаан, хэл найруулгын байтугай, цэг таслалын алдаа ч гаргалгүй бичиж, нэвтрүүлж байж сая ард

түмнийхээ оюун санааг гэгээрүүлэх үүргээ биелүүлж чадна.

"Телевизийн сэтгүүл зүйн шинэ үүрэг бол нэгдмэл цогц мэдээллийн, соёлын болон оюун санааны орон зай, хадгалахад оршино гэсэн ойлголт байдаг билээ"⁴. Сэтгүүлч, редакторын хайнга байдал, ур чадвар дутуу дулимагаас болж хэлэх гэсэн утга санаа эх бичвэр дээр өөр өнгө аясаар бууж, дүрс, уншилтын алдаанаас болж бүр эсрэг байр суурийг ч илэрхийлэх

«

Өнөөдөр Монголд телевизийн салбар хөгжлийнхөө нэг үе шатанд явж, шинээр олон телевиз төрөн гарч байна.

Нэг талаар телевизийн урлагт өрсөлдөөн бий болгож, үзэгчдийг сонголттой, мэдээллийг олон ургальч байдлаар хүргэх боломж олгож байгаа боловч нөгөөтэйгүүр сэтгүүлч, хөтлөгчдийн боловсрол, чадвар үзэгчдэд гологдож, чамлалттай байгаа нь ажиглагдаж байна.

»

соёл, чадвар юм"⁵. Телевизийн хэл найруулга нь зөвхөн бичвэрээс шалтгаалахгүй, тухайн бичвэрийг уншиж хүргэж байгаа хөтлөгч, нэвтрүүлэгч, сэтгүүлчийн үйл хөдлөл, нүүрний хувирлаас давхар шалтгаалдаг учраас бусад мэдээллийн хэрэгслийн бичлэгээс онцлогтой.

Телевизийн хэл найруулга нь харьцангуй хожуу үеэс судлагджээ. Цаашид ч улам нарийвчлан судлах шаардлага байгаа юм. Найруулга зүй бол хэлийг уран яруу, утга төгөлдөр, учир шалтгаантай, зөв цэгцтэй, энгийн ойлгомжтой, товч тодорхой байлгах хэм хэмжээг бий болгож мөрдүүлдэг арга ухаан билээ. Харин телевизийн хэл най-

руулга аман ярианд тулгуурладаг. "Ярьдаг бичвэр буюу хамгийн энгийн ойлгомжтой үгээр үйл явдлыг илэрхийлэх"⁶ гэж хэлж болно. Гэхдээ энэ нь энгийн ярианы үг хэллэгээр дүүрэн байхын нэр биш. Телевизийн бичвэрийг бичгийн хэлний дүрэм ёсоор бэлтгээд түүнийг энгийн, ойлгомжтой ярианы хэлээр илэрхийлнэ. Телевизийн хэлийг аман ба бичгийн хэлний алинд нь хамааруулах вэ гэдэг анхаарал татсан асуудал мөн. Хөтлөгч, сэтгүүлч, редакторын ярьж байгааг харахад аман ярианы төрөлд орж болох ч хүмүүсийн хэл сэтгэхүй, оюун санаанд нөлөөлж, танин мэдэхүйн мэдээлэл, мэдлэг өгөх зорилготой учраас хэл найруулгын хэм хэмжээ, дүрэм журмыг баримталж ярих шаардлагатай юм. Ямар ч тохиолдолд телевизийн сэтгүүлчдийн баримтлах гол зарчим гэж бий. Үүнд:

- Үзэгч сонсогч ухаарч ойлгоход хялбар байхаар мэдээллээ хүргэх.

- Логик дараалалтай ярьж, мэдээллээ хүргэх.

- Эгэл жирийн байдлыг эрхэмлэх буюу хэт чамирхал, гоёж гоодсон ярианаас татгалзах.

- Товч, оновчтой ярьж үг хэмнэх, үг давтахгүй байх.

- Этгээд үг хэллэг, бүдүүлэг үг, гадаад үгийг аль болох хэрэглэхээс зайлсхийх.

- Хэл ярианы баялагтай байх зэрэг чанарыг заавал эзэмшсэн байх учиртай.

Телевизэд үзэгчдийг үйл явдалд хөтлөх чиглүүлэх гол үүргийг сэтгүүлч, хөтлөгч, нэвтрүүлэгч гүйцэтгэдэг. Тэд үзэгчдэд хүргэх гол санааг хэл яриагаар дамжуулж, бичвэрийг зөв ойлгоход чиглүүлж, сэтгэлийн хөдөлгөөнөөр үзэгчдийг үйл явдал дунд оруулах учиртай. Нэг ёсондоо тухайн үйл

явдлын хөндлөнгийн ажиглагч мэт боловч бусдыг дагуулах гол тоглогч байдаг. Үзэгчдийг байлдан дагуулж, тэдний татах зорилгоор зарим хөтлөгч, сэтгүүлч хэт бүдүүлэг үг хэрэглэх, гудамжны үгээр ярих, хэт олон тоо ашиглаж, албаны, нарийн мэргэжлийн үг ашиглах нь бий.

Мэдээллийн хүчтэй хэрэгсэл болох телевизээр хар ярианы үг, албаны яриа, гудамжны этгээд үг хэллэг, гадаад үгтэй эрлийжсэн үг, харь хэлний үг зэргийг хольж хутган ярих нь үзэгчдээ хүндлээгүй хэрэг юм. "Эх захаа алдсан гадаад үг хэллэг хэмжээнээсээ хэтэрч, жирийн уншигч, үзэгч залхаж гүйцсэн нийг олон жишээ баримтаар тайлбарлаж болно. Сэтгүүлчдийн гадаад хэлний мэдлэгийг сайжруулах, найруулан бичих, хянан боловсруулах чадварыг эрс дээшлүүлэхгүйгээр асуудлыг шийдвэрлэх боломжгүй билээ"⁷. Телевизийн уран бүтээлч хүн тэр тусмаа сэтгүүлч, хөтлөгч, нэвтрүүлэгчид хэлний бодлогыг хэрэгжүүлэх үйлсийн тэргүүн шугамд ажилладаг тул эх хэлний мэдлэг өндөр байхыг өнөөгийн цаг үе, нийгэм шаардаж байна.

Ишлэл

¹ Норовсүрэн Л., Ариунзаяа Н. 2009. Телевизийн сэтгүүл зүй. УБ., 94 дэх тал.

² Зулькафиль М. 2009. Сэтгүүлчийн ур чадвар. УБ., 280 дахь тал.

³ Норовсүрэн Л., Ариунзаяа Н. 2009. Телевизийн сэтгүүл зүй. УБ., 72 дахь тал.

⁴ Норовсүрэн Л., Ариунзаяа Н. 2009. Телевизийн сэтгүүл зүй. УБ., 80 дахь тал.

⁵ Зулькафиль М. 2009. Сэтгүүлчийн ур чадвар. УБ., 281 дэх тал.

⁶ Besse V., Desormeaux D. 2007. Television news reporting from design to delivery. Paris, p. 104.

⁷ Зулькафиль М. 2009. Сэтгүүлчийн ур чадвар. УБ., 283 дахь тал.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Дэлгэрцэцэг М. 2006. Телевиз. УБ.
2. Зулькафиль М. 2009. Сэтгүүлчийн ур чадвар. I дэвтэр. УБ.
3. Наранжаргал Х. 2006. Телевизийн сэтгүүл зүй. УБ.
4. Норовсүрэн Л, Ариунзаяа Н. 2009. Телевизийн сэтгүүл зүй. УБ.
5. Сүхбаатар Ц. 2009. Монгол хэлний найруулга зүй. УБ.
6. Юровский А. Я. 1998. Место телевидения в системе средств массовой коммуникации. М.
7. Besse B., Desormeaux D. 2007. Television news reporting from design to delivery. Paris.

Abstract

The article discusses the critical analysis of Mongolian television language. Compared to other countries, public media and TV are now at the developing stage in Mongolia. Journalist should have skills and ability on stylistics with selection of definite words and correct sequence of statements. Stylistic errors such as misspeak, missay, grammatical mistakes, using wrong words, grammatical harmful for young people to develop out their writing and speaking skills. TV language and its stylistics issues are not commonly reviewed and studied in the recent years, therefore further research studies required to be done in this field.